

БАТЛАВ:  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГА  
Д.МӨНХСАЙХАН  
.....оны.....дугаар сарын .....

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, УУРХАЙ АШИГЛАХ,  
ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ДЭД БҮТЦИЙГ  
ХӨГЖҮҮЛЭХ, АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ  
/”МОНГОЛБОЛГАРГЕО” ХХК/**

2023 оны 06 дугаар сарын ...

Дугаар 2023/66

Номгон

Энэхүү гэрээг нэг талаас: Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар түүнийг төлөөлж Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Т.Хишигбаатар, нөгөө талаас ашигт малтмалын MV-000456 тоот тусгай зөвшөөрөл эзэмшигч “Монголболгаргео” ХХК (цаашид “Тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэх) түүнийг төлөөлж Захирал Д.Лхагвасүрэн нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 31 дүгээр зүйлийн 31.1, Газрын хэвлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.3, 8 дугаар зүйлийн 8.2.3, Ашигт малтмалын тухай хууль 42 дугаар зүйлийн 42.1, 42.3, Захиргааны ерөнхий хуулийн 52 дугаар зүйлийн 52 дугаар зүйлийн 52.1, 52.2.1, 56 дугаар зүйлийн 56.1, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.9 дэх хэсгийг тус тус үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2023 оны 06 дугаар сарын ...-ны өдөр Баянхонгор аймаг Баянхонгор суманд байгуулав.

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1.Энэхүү гэрээ нь Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу олгосон MV-000456 тоот тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрөл бүхий талбай орших аймаг, сумын байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сайн дурын үндсэн дээр энэхүү Гэрээнд зааснаар дэмжлэг үзүүлнэ.

1.3.Энэхүү Гэрээ нь Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн MV-000456 тоот тусгай зөвшөөрөлд хамаарна.

### **Хоёр. Засаг даргын эрх, үүрэг**

2.1. Энэхүү гэрээний хүрээнд Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөлөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангах;

2.1.2. Гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч, саналыг нь авах;

2.1.3. Энэхүү гэрээний хэрэгжилттэй холбоотой уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан төсөл, арга хэмжээнээс тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран хэрэгжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг сонгож, түүнтэй зөвшилцсөний үндсэн дээр энэ тухай иргэдэд мэдээлэх;

2.1.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байр болон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэн ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулах;

2.1.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн техник эдийн засгийн үнэлгээ болон зохих байгууллагаар хянуулсан уулын ажлын төлөвлөгөө, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих;

2.1.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгөх;

2.1.7. Гэрээ байгуулж үйл ажиллагаа эхэлсэн аж ахуйн нэгжид сум орон нутаг, төрийн байгууллагын албан хаагчид, иргэдээс хууль бус дарамт шахалт үзүүлэх асуудлыг таслан зогсоох, буруутай этгээдэд арга хэмжээ авах;

2.1.8. Ашиглалтын аж ахуйн нэгжүүдийн биологийн болон техникийн нөхөн сэргээлтийн явцад холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт тавих ажлыг эрчимжүүлэх;

### **Гурав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг**

3.1. Энэхүү гэрээний хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. Үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг

зохих журмын дагуу Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж шийдвэрлүүлэх;

3.1.2.Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтад хамруулах талаар Хөдөлмөр, халамж үйлчилгээний газартай хамтарч ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр Хөдөлмөр халамж үйлчилгээний газраар дамжуулан эсвэл олон нийтийн хэрэгсэл болон цахимаар нийтэд зарлах;

3.1.3.Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах;

3.1.4.Ажиллах хүчнийхээ 50-иас доошгүй хувийг орон нутгаас ажиллуулах, Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын мэдээллийн санд бүртгэлтэй иргэдээс ажилд авах;

3.1.5 Хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ болон үйл ажиллагааныхаа талаар тухайн аймаг (сум)-ийн иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч байх;

3.1.6.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, зохих байгууллагаар хянуулсан уулын ажлын төлөвлөгөө, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ зэргийг биелүүлж ажиллах;

3.1.7.Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөөнд тусгагдсан техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг бүрэн хийж гүйцэтгэх;

3.1.8.Гамшгийн үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх;

3.1.9.Эрх бүхий байгууллага албан тушаалтнаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлж ажиллах;

3.1.10.Уул уурхайн ил тод байдлыг бий болгож, олборлосон баялаг, татвар төлбөрөө тайлагнаж байх;

3.1.11.Олборлосон металлыг Баруун бүсийн үнэт металлын сорьц тогтоох лабораториор баталгаажуулж, Монгол банк болон эрх бүхий арилжааны банканд тушааж байх;

3.1.12.Уурхай эрхлэхэд шаардагдах Ашигт малтмалын тухай хуулийн 35.3-р зүйлд заасан бичиг баримтын бүрдлийг бүрэн хангасан тохиолдолд ажлаа эхэлж байх;

3.1.13.Нийгмийн хариуцлагынхаа хүрээнд аймаг, сумын өмнө тулгамдаж байгаа аливаа асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх талаар санал санаачилга гаргах;

3.1.14.Орон нутагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнтэй ижил төрлийн бараа бүтээгдэхүүнийг гаднаас буюу бусад зах зээлээс авахгүй байх, орон нутгийн тухайлсан ААН-тэй гэрээ байгуулах;

3.1.14.1.Мах, сүү, хүнсний ногоог 100% тухайн орон нутгийн иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан худалдан авах;

3.1.14.2.Ажлын хувцас, дээжний уутийг тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулан худалдан авах;

3.1.14.3.Харуул хамгаалалтыг сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжид давуу эрх олгох;

3.1.15.Аж ахуйн үйл ажиллагааны ашгаас авах татвараас бусад татвар шимтгэлүүдийг орон нутгийн төсөвт төлдөг байх;

3.1.16.Ус ашигласны төлбөрийг тоолуураар хуулийн хугацаанд нь төлнө. Хэрвээ усны тоолуур суурилуулаагүй бол Эрх бүхий байгууллагаас баталсан дүгнэлтийг үндэслэн Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаатай ноогдуулалтын гэрээ хийж, төлбөрийг орон нутагт тушаана. Ус ашигласны төлбөрийг дүгнэлтээр төлөх тохиолдолд 50-иас доошгүй хувийг ажил эхлэхэд Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна;

3.1.17.Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.18, 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалтыг хэрэгжүүлэх;

3.1.18.Гэрээний хэрэгжилтийн техник хяналтын зардал болох 1,000,000 (Нэг сая) төгрөгийг Баянхонгор аймгийн төрийн сангийн "БХ-Хяналт техник - 100030051370" тоот дансанд гэрээ байгуулсны дараа байршуулна;

#### **Дөрөв. Хамтын ажиллагааны хороо**

4.1.Талуудын гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хамтын ажиллагааны хороо (цаашид "хороо" гэх)-г Засаг даргын Тамгын газар, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулна.

4.2.Хороо нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд талуудын оролцоог тэгш хангасан байна. Хорооны бүрэлдэхүүнд орох иргэдийн төлөөллийг иргэдийн Нийтийн Хурлаас нэр дэвшүүлнэ. Хорооны бүрэлдэхүүнийг тухайн шатны Засаг дарга томилж, чөлөөлнө.

4.3.Хороо гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

#### **Тав. Гэрээний хэрэгжилт**

5.1.Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээ, түүнтэй холбогдсон баримт бичгийг талуудын цахим хуудсанд ажлын 3 хоногийн дотор байршуулна. Гэрээний хувийг ажлын 5 хоногийн дотор аймаг (сум)-ийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлд хүргүүлнэ.

5.2.Талууд гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тайланг дараа оны 02 дугаар сарын 1-ний дотор аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

5.3.Талууд гэрээний тухайн жилийн биелэлтийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймгийн Засаг дарга болон геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

#### **Зургаа. Гэрээний хариуцлага**

6.1.Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй.

6.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээ байгуулсан эсэх талаарх мэдээллийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

#### **Долоо. Маргаан шийдвэрлэх**

7.1.Гэрээг тайлбарлах болон гэрээний хэрэгжилттэй холбоотой маргаан, зөрчлийг тухай бүр, эв зүйгээр шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдлоо шүүхэд гаргаж болно.

#### **Найм. Гэрээ хүчин төгөлдөр болох**

8.1.Талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

8.2.Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно.

8.3.Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.

8.4.Гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэнэ.

#### **Ес. Төсөл хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах**

9.1.Талууд тухайн аймаг, сумын иргэдийн санал хүсэлтэд суурилсан, аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлагдсан байгаль орчин, хүн амд нөлөөлөх нөлөөллийг бууруулах, дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зэрэг орон нутгийг хөгжүүлэх төсөл, арга хэмжээнээс сонгон хамтран хэрэгжүүлж болно.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО,  
ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Т.ХИШИГБААТАР

Хаяг: Баянхонгор сум, Номгон 1-р баг,  
Нутгийн удирдлагын ордон, 201 тоот

Утас: 88112834

"МОНГОЛБОЛГАРГЕО" ХХК-НИЙ  
ЗАХИРАЛ

Д.ЛХАГВСАҮРЭН

МОНГОЛБОЛГАРГЕО  
ХХК

Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан  
дүүрэг, 19-р хороо, Монголболгаргео  
ХХК-ний байр

Утас: 99117179

